

17



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 19

Номгон

Аймгийн Засаг даргын дэргэдэх
Гадаад харилцаа, аялал жуулчлалын
албыг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1а/75 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн Засаг даргын дэргэдэх Гадаад харилцаа, аялал жуулчлалын албыг 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн татан буулгасугай.

2. Гадаад харилцаа, аялал жуулчлалын албыг татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.

3. Гадаад харилцаа, аялал жуулчлалын албанд бүртгэлтэй үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

D:/2021/Alban bichig/togtool-2021

0121008